

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 3 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

Улсын Их Хурал /УИХ/-д өргөн бариад байгаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын талаар ажлын хэсгийн хүрээнд харилцан санал солилцож, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар оруулахаар боллоо. Түүнчлэн Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараагийн шатны төлөвлөгөөний төсөлд яамдаас ирүүлсэн саналыг нэгтгэн, Засгийн газарт оруулахад бэлтгэв.

УИХ-д өргөн барьсан “Нийгмийн даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд санал авах, зохих саналыг нэмж тусгах, олон нийттэй нийгмийн даатгалын чиглэлээр ажиллах төлөвлөгөө боловсруулах зэрэг ажлыг гүйцэтгэв. Түүнчлэн Бүх нийтийн тэтгэврийн тогтолцооны хуулийн төсөл, үзэл баримтлал, тооцооллыг боловсруулж, Дэлхийн банкнаас ирүүлсэн Тэтгэврийн шинэчлэлийн хувилбаруудтай танилцаж, санал боловсруулаад байна.

Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх журмын төслүүд болон Засгийн газрын “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”, “Тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай” тогтоолын төслүүдэд яамдын санал авч нэгтгэн, шийдвэрлүүлэхээр Засгийн газарт өргөн барив.

“Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд сурталчлах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:

- Нийгмийн халамжийн багц хуулинд нэмэлт, өөрчлөлт орсоны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт хамрагдагсад, ахмад настан, жирэмсэн эх болон шинэ гэр бүлд зориулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, үйлчилгээ, ахмад настны нийгмийн хамгааллын арга хэмжээ, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдэд үзүүлэх амьжиргаанд туслах нөхцөлт мөнгөн тусламж, шинэ төрсөн хүүхдийн болон шинэ гэр бүлийн мөнгөн тусламж, хүүхдийн мөнгөн тусламж, жирэмсэн болон нярай хүүхэдтэй эхэд олгох тэтгэмжийн талаар асуулт, хариулт хэлбэрээр 10 гаруй төрлийн гарын авлага, танилцуулга бэлтгэн 200 орчим иргэдэд тараав.

- Яамны болон нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Баянгол, Сүхбаатар дүүргийн нийгмийн халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнүүд иргэдийн сонирхсон асуудлаар хариулт өгч, иргэдээс тавьсан тодорхой асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэх арга хэмжээ авав.

- Байнгын асаргаа шаардлагатай иргэний нөхцөлт мөнгөн тэтгэмж, амьжиргаанд туслах нөхцөлт мөнгөн тусламж, нийгмийн халамжийн тэтгэвэр, ахмад настны рашаан сувиллын болон протезийн үнийн хөнгөлөлт зэрэг асуудлаар 30 орчим иргэнд зөвлөгөө өгч асуудлыг нь холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүллээ.

Нийгмийн ажилтныг мэргэшүүлэх 3 дахь шатны сургалт, нийгмийн халамжийн багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийг сурталчлан таниулах сургалтыг хамтатган аймаг, дүүрэг тус бүрт сум, хорооны нийгмийн ажилтан, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн ажилтан нийт 1038 ажилтанд 2008 оны 4 сарын 6-наас 5 сарын 15-нд сургалт зохион байгуулахаар сургалтын хуваарь, төсвийн тооцоог боловсруулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар батлуулав.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороотой хамтан НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Хүүхэд хамгааллын асуудлаар сургагч багш бэлтгэх 4 өдрийн сургалтыг зохион байгуулав. Сургалтад Нийгмийн цогц суурь үйлчилгээний хөтөлбөр хэрэгждэг Дорнод аймаг болон нийслэлийн Багануур, Баянгол, Баянзүрх дүүргийн нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, хөтөлбөрийн зохицуулагчид оролцсон бөгөөд хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлогын талаар мэдээлэл хийлээ.

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын удирдлага, ажилтнуудад зориулсан “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын үйлчилгээний стандарт” сэдэвт семинарыг зохион байгуулав. Семинарт оролцогчдод хүүхдийн эрх хамгаалал, түүнтэй холбоотой эрх зүйн орчин, хүүхдэд үзүүлдэг үйлчилгээний төрлүүдийн талаар мэдээлэл хийж, стандартын талаарх ерөнхий ойлголт өглөө.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулав.

“Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо”-ны тавьсан шаардлагыг судлан үзэж, “Бэст” массаж төвийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 10.0 сая, Нөхөн сэргээх үйлчилгээ, брайль ном хэвлүүлэхэд нь 28.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх, мөн Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн барилгыг засварлах, зарим тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 265.0 сая төгрөг олгохоор болж, 2008 онд хамтран ажиллах гэрээ байгуулав.

“Засгийн газар 100 хоног” нээлттэй хаалганы өдрийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, харьяа агентлаг, байгууллага болох Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, төв, орон нутгийн Нийгмийн даатгалын болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүд, Сэргээн засалтын үндэсний төв, Мэргэжлийн өвчин судлалын төвүүд 2008 оны 3 дугаар сарын 7-ны өдөр нэгэн зэрэг зохион байгуулав.

Боловсролын салбарт:

“Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, УИХ-д өргөн барихаар тогтлоо. Энэ хуулийг баталснаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, түүнд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, чадавхийг бэхжүүлэх, багш, албан хаагчдын ажиллах орчин, нийгмийн баталгааг хангахад чухал ач холбогдолтой юм.

“Сургуулийн өмнөх боловсрол-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанаар танилцууллаа. “Сургуулийн өмнөх боловсрол-2” үндэсний хөтөлбөрийг 2001-2007 онд хэрэгжүүлснээр сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2001-2007 онд 23.5 хувиар өсч 2007 онд 57.1 хувьд, мэргэжлийн багшийн хангалт 93.3 хувьд хүрч 0.7 хувиар тус тус өссөний гадна улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээ 29.1 тэрбум болж, 2005 оныхоос 18.3 хувиар нэмэгдсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх, 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэх бэлтгэлийг эрчимжүүлэх асуудлын хүрээнд “Шинэ тогтолцоо-шинэ үр дүн” сэдэвт семинарыг зохион байгуулж, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, Боловсрол, соёлын газрын дарга болон олон улсын байгууллага, хандивлагчдын төлөөлөл бүхий 110 хүн оролцлоо.

Энэхүү семинарын үр дүнд 2008-2009 оны хичээлийн жилээс 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургах бэлтгэлийг орон нутагт хангах талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ байгуулав. Энэхүү гэрээнд тус яам болон орон нутагт хийх ажлын чиглэл, хоёр талын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой зааж өгсөн болно.

Түүнчлэн Монголын радиогийн Боловсрол студитэй хамтран долоо хоног бүрийн Пүрэв гаригт бага, дунд боловсролын асуудлаар цуврал шууд нэвтрүүлгийг зохион байгуулж, МҮОНТ болон Боловсрол суваг телевизтэй Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх болон 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэн суралцуулах ажлын мэдээлэл, сурталчилгааны талаар төлөвлөгөө гаргаж хамтран ажиллаж байна.

“Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийн хүрээнд худалдан авах 10.000 компьютер, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг санхүүжүүлэх тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүллээ.

2008-2009 хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 10 нэрийн сурах бичгийг шинээр болон шинэчлэн, 2 нэрийн сурах бичгийг дахин хэвлэхтэй холбогдуулан БСШУ-ны сайдын тушаалаар “Сургуулийн номын сангаар дамжуулан эмзэг бүлгийн өрхийн хүүхдэд олгох сурах бичгийн хяналтын тоо”-г батлан, 12 нэрийн 135784 сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан үнэ төлбөргүй олгохоор боллоо.

Улсын төсвийн 3.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар багш бэлтгэдэг 7, нийслэлийн 80, аймаг, сумын ерөнхий боловсролын 105 нийт 192 сургуульд тус бүр 21 компьютер /багшийн 1, сурагчийн 20/ болон принтер, проектор, дэлгэц бүхий зайн сургалтын лаборатори байгуулж, мэдээллийн технологийн сургалтын үр дүнг ахиулах бодит боломжийг өргөжүүлээ.

Соёлын төвүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр өнгөрсөн оноос сумын соёлын төвийг 5 орон тоотой болгож, нийт 759 ажилтныг шинээр авч ажиллуулсан бөгөөд үүнтэй холбогдуулан төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулж байна. Дорнод, Төв, Булган, Дундговь, Говьсүмбэр, Завхан, Баянхонгор, Дархан-Уул аймгуудын соёл, урлагийн байгууллагуудын ажилтан, уран бүтээлчдэд зориулсан сургалт явууллаа.

“Уран болон атомын эрчим хүч ашиглах талаар Монгол Улсын төрөөс баримтлах бодлого”, “Уран болон атомын эрчим хүч ашиглах талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр”, “Атомын эрчим хүчний тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцлээ.

БСШУЯ-ны “Нээлттэй мэдээллийн өдөр”-ийг Сүхбаатарын талбайд зохион байгуулж, боловсролын 21, соёл, урлагийн 16, шинжлэх ухааны 11 байгууллагаас гадна боловсролын гол хандивлагч байгууллага болох Азийн хөгжлийн банкны “Боловсролын хөгжлийн хөтөлбөр”, Дэлхийн банкны “READ” төсөл, “Үр дүнд түргэн хүргэх санаачилга” төсөл зэрэг 42 байгууллага оролцож, 3000 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүллээ.

Эрүүл мэндийн салбарт:

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний 3 дахь хөтөлбөрийн эхний жилийн биелэлтийн явц, “ДХВ/ДОХ-той тэмцэх үндэсний стратегийн хэрэгжилтийн байдал” зэрэг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргав.

Нээлттэй хаалганы өдрийг “Үйлчлүүлэгчид ээлтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээ” уриан дор зохион байгууллаа. Уг арга хэмжээнд төв, хөдөөгийн эрүүл мэндийн бүх байгууллагууд оролцож иргэдэд төлбөргүй үзлэг шинжилгээ хийсэн бөгөөд арга хэмжээнд эмзэг бүлгийн болон эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг хамруулах ажлыг Улсын нийгмийн даатгалын газартай хамтран зохион байгуулав.

Мөн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 80 дугаар тушаалаар Засгийн газрын 2007 оны 13 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, нийгмийн эмзэг бүлгийн, бүртгэлгүй, эрүүл мэндийн даатгалгүй иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай үзүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбарын “Нээлттэй өдөр”-ийг улсын хэмжээнд сар бүрийн нэг дэх долоо хоногийн Пүрэв гаригт зохион байгуулж байхаар шийдвэрлэлээ. Энэ өдрийн төлбөргүй тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөө, эмийн бус нөхөн сэргээх эмчилгээ, нэн шаардлагатай рентген, чанд авиа, зүрхний цахилгаан бичлэг, цус болон шээсний ерөнхий шинжилгээ хийх зэрэг үйлчилгээг хамруулахаар болов.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хамтарсан “Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг тогтоох тухай” тушаалаар өртөг ойролцоо оношийн бүлгээр нэг даатгуулагчийн хэвтэн эмчлүүлэх, өдрийн эмчилгээний, амбулаторийн тусламж үйлчилгээний суурь тариф ба зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний үзлэг оношлогоо шинжилгээний тариф, оношийн бүлгийн коэффициент, нэг даатгуулагчийн хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг тохиолдлоор санхүүжүүлэх хэмжээ зэргийг тус тус баталж, 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөхөөр шийдвэрлэв.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 73 дугаар тушаалаар нийслэл хотоос Говь-Алтай аймгийн Цээл, Сэлэнгэ аймгийн Хушаат, Мандал, Завхан аймгийн Тэлмэн, Түдэвтэй, Дорноговь аймгийн Эрдэнэ, Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан, Өвөрхангай аймгийн Хужирт суманд тус бүр нэг эмчийг 3 жилийн гэрээгээр ажиллуулахаар шийдвэрлэж, гэрээгээр ажиллах эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, гэрээг дүгнэж гэрээнд заасан хугацаанд Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд ирүүлж байхыг нэр бүхий аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болголоо.

“Бээжин-2008” зуны олимпийн наадамд оролцох үндэсний шигшээ багийн тамирчид, дасгалжуулагч, шүүгч, албаны төлөөлөгчид, сурвалжлагч нарын өмсөх хувцасны загварыг баталж, багийн бүрэлдэхүүнийг БНХАУ-ын “Ли Нин” компаниас үнэгүй олгогдох спортын хувцас хэрэгслээр хангах, татан авахад шаардагдах хөрөнгийг Биеийн тамир, спортын төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргахаар шийдвэрлэв.

Засгийн газрын 2008 оны 60 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотноо 2008 оны 4 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Ази тивийн Оюутны аварга шалгаруулах ширээний теннисний анхдугаар тэмцээнийг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталж, тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 65.3 сая төгрөгийг биеийн тамир, спортын төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргахыг Биеийн тамир, спортын улсын хороонд даалгав.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 65 дугаар тушаалаар “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн санхүүжилтээр худалдан авсан 78,1 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээ, үнийн жагсаалтыг баталж, нэр бүхий 16 аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд тус тус хуваарилан олгосон байна.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 57 дугаар тушаалаар “Дадлагажигч их эмчийн ажиллах журам”-ыг батлан мөрдүүлэв. Уг журмаар дадлагажигчийг гурваас доошгүй жил ажилласан, эмчлэх эрхтэй хүний их эмчийг дагалдуулан ажиллуулах бөгөөд дадлагажигч их эмчийн үйл ажиллагаа явуулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулахаар болсон байна.

ДЭМБ-ын шугамаар ирсэн олон улсын шинжээчдийн баг 2 дугаар сарын 19-нөөс 3 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд Дархан-Уул аймгийн Хонгор, Хушаат сумдад ажиллаж, хүн амын дунд байгаа цианид хордлогын байдлын урьдчилсан дүнг Засгийн газарт мэдээлэв.

Засгийн газрын 2008 оны 98 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 79 дүгээр тушаалаар Дархан-Уул аймгийн Хонгор сумын хүн амын дунд арьсны мэргэжлийн эмч нарын үзлэг хийх, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамж, эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус баталж, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад даалгав.

Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтлоо. Энэхүү хуулийн хэрэгжилттэй холбогдон гарч буй маргаантай асуудлыг шийдвэрлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжилтийг хангах, татварын бааз суурийг өргөтгөх, улмаар үйлдвэрийн аргаар дотооддоо борлуулсан махыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зэрэг заалтыг нэмж оруулахаар тусгасан байна.

2007 оны нэгдүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай (*шинэчлэн найруулсан*) хуулиар маханд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах болсноор махны үнийг тогтвортой байлгах бололцоог багасгаж, үйлдвэрлэгчид дотооддоо мах бэлтгэж нийлүүлэхээс илүүтэй экспортлох сонирхолтой байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үйлдвэрийн аргаар бэлтгэж, дотоодын хэрэгцээнд нийлүүлсэн махыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлбөл хямд үнээр мах экспортлох явдал багасч, дотоод зах зээл дэх махны үнийг тогтворжуулах боломж гарна гэж үзэж байна.

Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг шинэчлэн батлах тухай Засгийн газрын (2008 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор 8 салбар, дэд салбарын 31 төрлийн хөрөнгө оруулалт, өргөтгөл, шинэчлэл явуулах жагсаалтыг шинэчлэн баталсан байна.

Засгийн газар Монгол Улсын төсөвт 2008 оны эхний хагас жилд тодотгол оруулах шаардлагагүй гэж үзсэнтэй холбогдуулан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын (2008 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, төслийг УИХ-д өргөн барихаар боллоо. Энэхүү хуулийн нэмэлтээр хөрөнгө зохицуулах эрхийг Засгийн газарт олгох, энэ зохицуулалтыг оруулахдаа тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан дүнг нэмэгдүүлэхгүйгээр, шинээр төсөл, арга хэмжээ нэмж оруулахгүйгээр зохицуулах харилцааг хуульчлахаар төсөлд тусгасан байна.

Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухай Засгийн газрын (2008 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын тогтоол гаргахаар болсон байна. Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс орны тулгамдсан асуудлаар санал боловсруулах, иргэний нийгмийн байгууллагуудын санал санаачилгыг дэмжих чиглэлээр Иргэний нийгмийн зөвлөлд төрийн зарим чиг үүргийг хариуцуулан гүйцэтгүүлж байхаар тогтсон байна. Энэхүү тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн гүйцэтгэлд хяналт тавих үйл ажиллагаанд төрийн бус байгууллагыг оролцуулах нөхцөл бүрдүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлэх Эрдэнэт хотын ус цэвэршүүлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл болон Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах сүлжээ байгуулах төслийн тухай Засгийн газрын (2008 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, БНФУ-ын Засгийн газрын 9.535 сая еврогийн хөнгөлөлттэй зээлээр Эрдэнэт хотын ус цэвэршүүлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл, 1.57 сая еврогийн хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэлээр БНФУ-ын Засгийн газартай зээлийн хэлэлцээ явуулахыг Сангийн сайдад зөвшөөрсөн байна. Энэхүү зээл нь 25 жилийн хугацаатай, эхний таван жилд үндсэн хүүгийн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй, зээлийн хүү нь жилийн 0.9 хувь байх ажээ. Зээлийн хэлэлцээг явуулж, хоёр тал Санхүүгийн протокол, зээлийн гэрээг (2008 оны 3 дугаар сарын 13-ны өдөр) үзэглэлээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн барихаар болов.

Засгийн газрын (2008 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн) хуралдаанаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлттэй танилцаж, түүнийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтлоо. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 5 бүлэг бүхий 122 төрлийн зорилт, арга хэмжээ тусгагдсан бөгөөд эдгээр зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2007 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж үзэхэд 58 буюу 47.5 хувь нь бүрэн биелсэн, 40 буюу 32.8 хувь нь 90 хувийн биелэлттэй, 19 буюу 15.6 хувь нь 70 хувийн биелэлттэй, 5 буюу 4.1 хувь нь 50 хувийн биелэлттэй, нийтдээ 90.0 хувийн биелэлттэй гарсан байна.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2007 оны төсвийн гүйцэтгэлийн тухай Засгийн газрын (2008 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн) хуралдааны үеэр Сангийн сайд Засгийн газрын гишүүдэд танилцууллаа. Монгол Улсыг хөгжүүлэх санд 2007 онд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 269.2 тэрбум төгрөг, Эрсдэлийн сангийн зарцуулагдаагүй хөрөнгийн орлого 7.7 тэрбум төгрөг, Монгол Улсын 2006 оны төсвийн ашиг 122.8 тэрбум төгрөг, сангийн хөрөнгийн үлдэгдэлд төлсөн хүүгийн орлого 0.5 тэрбум төгрөг (нийт 400.0 тэрбум төгрөг)-ийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсвийн зарлагыг 2007 онд 303.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 271.6 тэрбум төгрөгийг; үүнээс: хөрөнгө оруулалтад 186.4 тэрбум төгрөг баталснаас 161.8 тэрбум төгрөг, “Үдийн цай” хөтөлбөрт 12.7 тэрбум төгрөг

баталснаас 12.4 тэрбум төгрөг, Хүүхэд, гэр бүлийг дэмжих арга хэмжээнд 104.6 тэрбум төгрөг баталснаас 97.4 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын тухай сонгуулийн өмнөх мэдэгдлийн тухай Засгийн газрын (2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, мэдэгдлийн төслийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлэхээр тогтлоо. Монгол Улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн байдлын тухай зарим тоо баримтыг дурдвал: Сүүлийн дөрвөн жилийн дунджаар ажилгүйдлийн түвшин эдийн засгийн идэвхтэй хүн амын 3.6 хувиас хэтрээгүй бөгөөд 2000-2003 оны дундажтай харьцуулахад 0.8 нэгжээр буурсан байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2008 онд 2003 оноос 3.6 дахин, төрийн болон төсөвт байгууллагад ажиллагчдын дундаж цалин 300.0 мянгад хүрч 2003 оныхоос 4.2 дахин нэмэгдсэн байна. Мөн 2008 онд бүрэн тэтгэврийн доод хэмжээ 81.000 төгрөгт, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 54.000 төгрөгт, тэтгэврийн дундаж хэмжээ 2004 оныхоос 2.8 дахин нэмэгдэж 93.000 төгрөгт хүрчээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 2004-2008 онуудад жилд дунджаар 9.0 хувьтай гарч ДНБ-ий өсөлт 2007 онд 9.9 хувьд хүрсэн байна. Хөрөнгө оруулалтын хэмжээ 2004-2008 онд нэг триллион 188.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онуудын нийт хөрөнгө оруулалтын хэмжээнээс 5.8 дахинаар нэмэгдсэн байна. Монгол Улсын төлбөрийн нийт тэнцэл 2007 оны гүйцэтгэлээр 284.9 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын нийт нөөц 972.2 сая ам.доллар, төсвийн нийт орлого 2007 оны гүйцэтгэлээр 1 триллион 851.2 тэрбум төгрөгт хүрч, 2004 оныхоос 2.6 дахин нэмэгдсэн байна.

Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах зөвлөлөөс Засгийн газрын (2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн) хуралдаанд газрын тосны бүтээгдэхүүн, гурил, махны үнийг тогтворжуулах чиглэлээр гүйцэтгэж буй ажлын мэдээллийг хийж, төсвийн байгууллагад арвилан хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг танилцууллаа. Засгийн газрын хуралдаанаас хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, түүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах үүднээс “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг яаралтай шийдвэрлүүлэхийг Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд нарт даалгасан байна. Түүнчлэн УИХ-аас зөвшөөрөл олгосны дагуу 15.0 мянган тонн гурил, 100.0 мянган тонн хүнсний буудайн нөөц бүрдүүлэх чиглэлээр хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзлээ. Мөн газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийг далимдуулан үнэ хөөрөгдөхөөс сэргийлэх, түүнд тавих хяналт шалгалтыг МҮЭ-ийн холбоо, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг зэрэг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга, Нийслэлийн Засаг дарга нарт даалгалаа.

Шатахууны үнэ өссөнтэй холбогдуулж Засгийн газраас төсвийн байгууллагуудад хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр тогтсон байна. Энэ зорилгоор “Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай” Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж, хотын дотор шатахуун бага зарцуулдаг автомашин хэрэглэхийг төсвийн бүх шатны эрх захирагчдад даалгах; албан тушаалын болон албан ажлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан батлагдсан нормативаас хэтрүүлсэн тохиолдолд нөхөн төлүүлдэг зарчмыг хатуу барих; төсвийн эрх захирагч нарт долоо хоногт нэг удаа унаа хэрэглэхгүй байхыг зөвлөх; бичиг хэрэг, шуудан холбоо, ус, цахилгаан, түлш, халаалтын зардлыг 5.0 хувь, эд хогшил худалдан авах зардлыг 50.0 хувь, гадаад, дотоод албан томилолт, гаднын зочны зардлыг 30.0 хувь бууруулах замаар батлагдсан төсвийг хэтрүүлэхгүй байх; байрны халаалтын хугацааг 15 хоногоор богиносгох зэрэг арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэв.

УИХ-ын 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны тэмдэглэл болон Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн зөвлөлийн 2008 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 2 дугаар шийдвэрийг үндэслэн Сангийн сайдын (2008 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 117 дугаар) тушаалаар Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх

болон зээлийн хүүгийн төлбөрийн урамшуулал олгох төслийг шалгаруулах, санхүүжүүлэх түр журмыг баталлаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Сангийн сайдын ([2008 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 125 дугаар](#)) тушаалаар Буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй 30 төсөл, түүний хэрэгжүүлэгч байгууллагын нэмэлт жагсаалтыг баталж, эдгээр төслийн шугамаар нийлүүлэгдэж буй бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Зээл, тусламжийн бодлого, зохицуулалтын газар, Төсвийн бодлого, зохицуулалтын газрын болон Үндэсний татварын газрын дарга нарт даалгалаа.

Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс Сангийн сайдын ([2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 128 дугаар](#)) тушаалаар Гадаадын зээл, тусламжийг үр дүнтэй ашиглах, нэгдсэн бодлогоор хангах ажлыг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Зээл, тусламжийн бодлогын зөвлөлийн ажиллах зөвлөлийн ажиллах журмыг баталлаа.

Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын ([2008 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 96/43 дугаар](#)) хамтарсан тушаалаар бензин, шатахууны жижиглэн худалдаалах үнийг 2007 оны 11 дүгээр сарын хэмжээгээр 2008 оны 1 дүгээр сард тогтвортой хадгалж үйлчилсэн газрын тосны бүтээгдэхүүний импортын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн зээлийн хүүгийн алдагдлыг нөхөхөд зориулан 8.8 тэрбум төгрөгийг улсын төсвийн дотоодын үйлдвэрлэгчдэд зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх эх үүсвэрээс санхүүжүүлэх шийдвэр гаргаж, түүнийг нөхөн олгосон байна.

Засгийн газраас Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг хангах, дотоодын зах зээлийн үнийн өсөлтийг саармагжуулах, дэлхийн зах зээл дэх зарим нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг харгалзан Монгол Улсын нийгэм, эдийн засагт гарч буй өөрчлөлтийг тусгах шаардлагын дагуу Монгол Улсын 2008 оны төсөвт тодотголын үндэслэл, холбогдох тооцоо, судалгаа, танилцуулгыг боловсруулж, түүнийг Засгийн газрын хуралдаанд хоёр удаа танилцууллаа. Монгол Улсын 2008 оны төсвийн тодотголоор төсвийн орлого 1.5 тэрбум төгрөгөөр буурах, төсвийн зарлага 210.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэх тооцоо гарсан байна. Мөн төсвийн тэнцлийн алдагдлын ДНБ-нд эзлэх хэмжээ -6.4 хувь болохоор тооцоо гарсан нь батлагдсан хэмжээнээс даруй 3.9 хувиар муудах төлөвтэй байна. Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, эдгээр хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдлийг боловсруулах ажлын хүрээнд 2009-2011 онуудын эдийн засгийн гол үзүүлэлтийг тооцож гаргасан байна. Экспортын хэмжээ 2010 оноос эрс нэмэгдэхийн зэрэгцээ импорт жилд 11.3-20.0 хувиар өсөх төлөвтэй байна. Гадаад худалдааны тэнцэл 2009 онд алдагдалтай байх боловч Оюутолгойн ордыг 2010 оноос ашиглаж эхэлснээр 2010-2011 онд ашигтай болох төлөвтэй байна. “Үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний (мах, гурилын) үнийг харьцангуй тогтворжуулах арга хэмжээ авснаар 2008 оны эцэст инфляцийн түвшин 8.0 орчим хувьтай байх төлөвтэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцлийн ДНБ-д эзлэх хувийг өмнөх онуудад байнга алдагдалтай төлөвлөж ирснийг өөрчилж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс төсвийн алдагдлыг ирэх 2009-2011 онуудад тэг (0) хувь байлгах нэгдсэн шийдэлд хүрсэн явдал санхүү, төсвийн бодлогод эргэлт хийсэн алхам боллоо. Эдийн засгийн бодит өсөлт (*урьдчилсан тооцоогоор*) 2008 онд 10.5 хувь, 2009 онд 11.1 хувь болсноор нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2009 онд 2106.7 ам.долларт, 2011 онд 3441.4 ам.долларт хүрэхээр байна.

Монгол Улсын төсвийн хүрээний 2009-2011 оны мэдэгдлийн төсвийн үндсэн үзүүлэлтийг боловсруулж, төсвийн хүрээний 2009 оны мэдэгдлийн тооцооны үндэслэлийг өөрчлөхөөр шийдсэн байна. Өмнөх жилүүдэд төсвийн орлогыг тооцсоны

дараагаар зарлагыг төлөвлөж, улмаар төсвийн алдагдлыг боддог байсныг 2009 оноос эхлэн эдийн засгийн бодлогыг мөнгөний бодлоготой уялдуулан төсвийн тэнцлийг эхэлж гаргасны дараагаар төсвийн орлого, зарлагыг тооцох шинэ аргачлалд шилжиж байна. Үүний дагуу төсвийн орлого, зарлагын ДНБ-нд эзлэх хувь хэмжээг 2009-2011 онуудад дунджаар 34.2 хувь, төсвийн нийт тэнцлийн ашгийг тэг (0) байхаар тооцоолсон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны хоёрдугаар сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж мэдээллээ. **Үүнд:**

(1) Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2008 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлээр **323.4** тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг **15.3** тэрбум төгрөгөөр буюу 5 хувиар давуулан биелүүлж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 90.0 тэрбум төгрөгөөр буюу 38.5 хувиар илүү байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг эх үүсвэрээр нь задалж үзвэл татварын орлогоор 82.4 хувийг, татварын бус орлогоор 17.0 хувийг, хөрөнгийн ба тусламжийн орлогоор 0.6 хувийг тус тус бүрдүүлсэн байна. Улсын нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 57.0 хувиар буюу 20.2 тэрбум төгрөгөөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 26.6 хувиар буюу 13.0 тэрбум төгрөгөөр тус тус давсан явдал голлон нөлөөлсөн байна.

(2) Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2008 оны хоёрдугаар сарын төлөвлөгөөгөөр 389.5 тэрбум төгрөг (үүнээс улсын төсвийн зарлага 308.2 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр **268.1** тэрбум төгрөгт хүрчж, төлөвлөсөн нийт зарлагын 68.8 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 117.3 тэрбум төгрөгөөр буюу 77.8 хувиар илүү байна. Нийт урсгал зардлын 12.0 хувийг нийгмийн халамжийн сангийн зардал, 33,0 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, өөрөөр хэлбэл, нийт зардлын 45 хувийг буюу 120.6 тэрбум төгрөгийг цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зардалд зарцуулсан байна.

(3) Орон нутаг 2008 оны хоёр сарын гүйцэтгэлээр төсвийн орлогын төлөвлөгөөг 8.6 хувиар буюу 1.8 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлж, төсвийн зарлагыг 80.2 хувиар буюу 3.9 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас нийт 5.67 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 4.65 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, нийслэл Улаанбаатар хот болон Сэлэнгэ аймаг төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

(4) Монгол Улсыг хөгжүүлэх санд 2008 оны эхний хоёр сард зарим бараа бүтээгдэхүүний албан татвараар 55.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, сангийн оны эхний үлдэгдлээс 0-16 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид 20.3 тэрбум төгрөг; Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 1.6 тэрбум төгрөг (нийт **21.9** тэрбум төгрөг)-ийг зарцуулсан байна.

(5) Монгол Улсын нэгдсэн төсвийн (өссөн дүнгээр) 2008 оны хоёрдугаар сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл **66.9** тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл **55.3** тэрбум төгрөгийн ашигтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 18.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 14.8 тэрбум төгрөгийн ашигтай) гарсан байна.

Улсын төсөвт байгууллагын 2008 оны хоёрдугаар сарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улсын хэмжээнд 2008 оны гуравдугаар сарын 1-ний байдлаар нийт авлага **4.38** тэрбум, нийт өглөг **5.11** тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь 2008 оны 1 дүгээр сартай зэрэгцүүлэхэд өглөг 489.0 сая төгрөгөөр буурсан, авлага 62.1 сая төгрөгөөр өссөн дүнтэй гарсан байна. Төсвийн нийт өглөгийн 19.4 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 14.2 хувийг тогтмол зардал, 5.6 хувийг тээвэр, шатахууны зардал, 12.6 хувийг хоол, эмийн зардал, 48.2 хувийг бусад зардал эзэлж байна.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу улс, орон нутгийн төсөвт байгууллагын 2008 оны нэгдүгээр улирлын төсвийн урсгал зардлын эрхийг хянаж, 2008 оны гуравдугаар сарын урсгал зардалд **16.8** тэрбум төгрөг нэмж гаргах замаар (өссөн дүнгээр) **315.3** тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. *Тухайлбал*, эхний улиралд халамжийн тэтгэвэрт 18,195.9 сая төгрөг (тухайн сард 6481.7 сая төгрөг), тэтгэврийн нөхөн олговорт 67.7 сая төгрөг (тухайн сард 29.6 сая төгрөг), тэтгэврийн даатгалын сангийн татааст 39.5 тэрбум (тухайн сард 12.9 тэрбум төгрөг) төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 9.0 тэрбум

төгрөг (тухайн сард 3.0 тэрбум төгрөг), шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 1369.3 сая төгрөг (тухайн сард 460.0 сая төгрөг), шинэ гэр бүлийн мөнгөн тусламжид 4927.8 сая төгрөг (тухайн сард 1555.3 сая төгрөг), алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмжид 8,271.7 сая төгрөг, түүнчлэн улс, орон нутгийн төсөвт байгууллагын урсгал төсвийн санхүүжилтэд 273,428.1 сая төгрөг олгосон болно.

Монгол Улсыг хөгжүүлэх сан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, Засгийн газрын нөөц сан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хураангуй ба дэлгэрэнгүй тайланг нэгтгэн гаргаж, дүнг долоо хоног тутам удирдлагад тайлагнан ажиллаж байна. Засгийн газрын шийдвэрийн дагуу 2008 оны эхний гурван сард Засгийн газрын нөөц сангаас 2166.0 сая төгрөг (тухайн сард 911.1 сая төгрөг)-ийг зарцууллаа. Мөн 2008 оны эхний гурван сард орон нутагт олгох НӨАТ-ын шилжүүлгээр 3021.5 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгээр 2688.4 сая төгрөгийг хуваарилан олгов.

Улсын төсвийн 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний батлагдсан хуваарийг програм хангамжид оруулж, төсвийн хуваарийн ёсоор санхүүжилт олгох боломжоор хангасан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008 оны эхний гурван сарын байдлаар нийтдээ **16136.9** сая төгрөг (тухайн сард 9559.8 сая төгрөг)-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Мөн батлагдсан хуваарийн дагуу эхний улиралд **6.4** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг орон нутгийн төрийн сангуудын хөрөнгө оруулалтын дансанд тус тус хуваарилан олгосон байна.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тусгай дансанд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар 2008 оны эхний гурван сарын байдлаар **74.0** тэрбум төгрөгийг төвлөрүүлж, **23.8** тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны 4 дүгээр сарын 1-ний үлдэгдэл **300.9** тэрбум төгрөг байна. *Тухайлбал*, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2.8 тэрбум төгрөг; 0-18 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид зориулан 21.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Үйлдвэр, худалдааны салбарт:

“Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна.

“Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж яамдаас санал авч байна.

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар тогтов.

“Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай” хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд УИХ-д өргөн барихаар тогтов.

“Монгол Улсын чөлөөт бүсийн үзэл баримтлал”-ын төслийг Засгийн газраар хэлэлцүүлэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулахаар бэлтгэв.

“Түүхий эд бэлтгэлийн зохицуулалтын тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл, уг хууль гарахтай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан яамдаас санал авч байна.

“Үнэт металл, эрдэнийн чулуун эдлэлийн худалдаа эрхлэх” үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр олгуулах тухай хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалыг боловсруулав.

Ноолуурын салбарт 2012 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.

Шинэ Засгийн газар байгуулагдсанаас хойш 100 хоногийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлыг сурталчлах “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулав.

Улсын төсвийн хөрөнгөөр 2008 онд үргэлжлүүлэх болон шинээр гүйцэтгэх геологийн судалгааны төслүүдийн 2008 оны ажлын төлөвлөгөөг Үйлдвэр, худалдааны

сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Увс аймгийн Өмнөговь сумын нутагт орших Орлогын голын 12282Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлаар УИХ-ын гишүүн Б.Эрдэнэсүрэн Үйлдвэр, худалдааны сайдад хүсэлт тавьсны дагуу холбогдох газруудтай хамтран асуудлыг шийдвэрлэв.

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 7 тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээж авав.

Геологийн төв лабораторийн 2008 онд мөрдөх шинжилгээний үнийг Үйлдвэр, худалдааны сайдын тушаалаар батлав.

Налайх дүүрэгт иргэд хувиараа нүүрс олборлож байгаа асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулав.

“Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.

Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого, 2015 он хүртэлх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв.

Газрын тосны хайгуулын Баянтүмэн-17 талбайд Магнай трейд ХХК, Хөх нуур-18 талбайд Эм-Пи-Ай ХХК-тай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх авах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар хүргүүлээд байна.

Стратегийн ач холбогдол бүхий орд болох Тавантолгой, Шивээ-Овоогийн нүүрсний орд, Төмөртэйн ордуудын асуудлыг шийдвэрлэж “Эрдэнэс МГЛ” ХХК-д шилжүүллээ.

“Металл боловсруулах үйлдвэрт тавих ерөнхий шаардлага” Үндэсний стандартыг боловсруулж, Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

Засгийн газраас 2008 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил” болгон зарласантай холбогдуулан импортын зарим нэрийн савласан бараа, бүтээгдэхүүний шошгыг монгол хэл дээр бичиж дотоодын зах зээлд нийлүүлэх, худалдаалах тухай асуудал, мөн “Худалдааны дунд хугацааны үзэл баримтлал”-ын төслийн талаар бизнесийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг хийж, семинар зохион байгуулав.

Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан алдагдал 12.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэв.

Дархан, Эрдэнэт, Хан-Уул, Налайх, Багахангайд үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг хөгжүүлэх болон паркт үйл ажиллагаа явуулах зарим аж ахуйн нэгжийн төслийг Сангийн яаманд хүргүүлэв.

Үйлдвэр, худалдааны яам, Монголын үйлдвэрлэл, үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны 2008-2009 оны салбарын хэлэлцээрт гарын үсэг зурав.

Байгаль орчны салбарт:

“Байгаль орчныг хамгаалах” тухай хуулийг батлуулав. “Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсний төлбөрийн тухай” хуулийн үзэл баримтлал, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан холбогдох төслүүдийг эцэслэн боловсруулж байна.

“Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журам”, “Таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах журам”, “Ой зохион байгуулалтын журам”-уудыг Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан тушаалаар батлав.

“Экологийн хохирлыг тооцох талаар авах зарим арга хэмжээний тухай” Байгаль орчны сайдын 2008 оны 103 тоот тушаал гаргаж Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, Мөрдөн байцаах газар, Усны

хэрэг эрхлэх газар, ШУА-ийн Ботаникийн хүрээлэн, Биологийн хүрээлэн, Ой, усны хайгуул судалгааны төв, аймаг, нийслэлийн Засаг дарга, Байгаль орчны албадад хүргүүлж, мөрдүүлж эхэлсэн нь эрүүгийн шинэ хуулийг хэрэгжүүлэх бодит боломжийг бий болгов.

“Ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журмыг” Байгаль орчны сайдын 2008 оны 79 тоот тушаалаар батлуулж, аймаг, нийслэлийн байгаль орчны албадад хүргүүлэв.

“Ой зохион байгуулалт хийх журам”, “Химийн хорт бодисуудыг шинжлэх лабораториудын түвшинг дээшлүүлэх тухай”, “Усны экологи эдийн засгийн үнэлгээ”, “Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах” хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар тус тус хэлэлцэн баталлаа.

Химийн хорт болон аюултай бодисын зөвшөөрөл олгох болон хяналт тавих механизмыг сайжруулах зорилгоор Байгаль орчны сайдын 2008 оны 102 тоот тушаалаар химийн бодисын тусгай зөвшөөрлийн системийг чангатгах, зохион байгуулалтын арга хэмжээг авч, химийн бодисын зөвшөөрлийг Төрийн нарийн бичгийн даргын түвшинд олгож байхаар шийдвэрлэв.

Эрүүл мэндийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газартай хамтран “Химийн аюултай хортой бодисийн менежментийн асуудал”-аар хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулав.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй лабораториудын чадавхийг сайжруулахад шаардагдах зардлыг гаргах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд химийн хортой болон аюултай бодисын бодлого зохицуулалтын үндэсний зөвлөлд хөрс, ус, агаарт хүнд металлын шинжилгээ хийх багаж авах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэв.

“Эм Эн Ар Ай Жи” ХХК нь 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтоор химийн хорт болон аюултай бодис импортлох тусгай зөвшөөрөлгүйгээр, тус бодисыг нэвтрүүлэх жагсаалтад ороогүй боомтоор, хил нэвтрүүлэхээр завдсаны улмаас хураагдан, битүүмжлэн хадгалагдаж байгаа бодисын талаар Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн Шинжээчдийн багийн зөвлөмж, Үндэсний зөвлөлийн тогтоол гарлаа.

Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын дотоод бүсчлэлийг тогтоож сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дахь Сүүж уулын районд 2 хүний бүрэлдэхүүнтэй байнгын хамгаалалтын постыг 30 хоногийн хугацаатай 2 ээлжээр гаргаж хууль бусаар алт олборлох үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлж байна.

Говийн их дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас Өмнөговь аймгийн Номгон сумын орчны бүс нутагт хууль бусаар алт олборлохоор ирсэн хүмүүсийн үйл ажиллагааг таслан зогсоолоо. Мөн Ханбогд сумын нутгийн орчны бүс нутаг болох Хадна ус, Нүдэнгийн ус, Улаан эрэг зэрэг 3 газарт хууль бусаар тээрэм ажиллуулж 50 орчим тонн шлам гаргасныг тогтоон, Хар овоонд суурилуулж орхисон тээрмийг илрүүлж холбогдох арга хэмжээг авч байна.

Говь Гурвансайхны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас нутгийн иргэдэд захидал тарааж, нутгийн 40 гаруй малчин өрхтэй байгаль орчин, газар нутгаа хамгаалах гэрээ байгуулан ажиллаж байна.

Түймрийн аюултай үе эхэлж байгаатай холбогдуулан түймрийн цагийн байдлын тухай шуурхай мэдээлэл авах, түймэртэй тэмцэх ажлыг удирдлагаар хангах үүрэг бүхий түймрийн хариуцлагатай жижүүрийг 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 10-ныг хүртэл ажиллуулахаар боллоо.

БНСУ-ын Цаг уурын газар, “КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны байгууллагын шугамаар Ус цаг уур орчны шинжилгээний газарт хэрэгжих 1.3 сая ам.долларын санхүүжилт бүхий “Ус цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээллийн архивт орчин үеийн цахим хадгалуур бүхий систем бий болгох нь” төслийг 2008 оны 6 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурав.

Барилга, хот байгуулалтын салбарт:

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуульд өөрчлөлт оруулах тухай, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг даган мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, УИХ-д өргөн барихаар болов.

“Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын төлөөлөгчийн газарт олгосон газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн барилаа.

Газрын нэгдмэл сангийн 2007 оны тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулан, тэмдэглэл гаргуулав.

Улсын хилийн зурвас газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

“Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл, “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, яамдаас санал авахаар хүргүүлэв.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн 2 дахь хувилбарын саналыг боловсруулах ажлын хүрээнд “Аймгийн төвд ойролцоо сумдыг аймгийн төвд нэгтгэх бололцоог тодорхойлох” нийгэм-эдийн засгийн газар зүйн судалгааны тайлан төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

2009 онд Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжих төслүүдийн жагсаалтыг боловсруулан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын ажлын байрны талаар авах арга хэмжээний тухай “Барилга шилжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдад хүргүүлэв.

НҮБ-аас зарласан “Ус- ариун цэвэр- эрүүл ахуйг дэмжих жил”-ийн нээлтийн ажиллагааг Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран зохион байгуулав.

2008 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 52 суманд ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж суурилуулах гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, тендерийн үнэлгээний хорооны үйл ажиллагааг дүгнэв.

Барилгын норм, норматив, дүрэм, заавар боловсруулах 8 ажлын техникийн даалгаврыг хянан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

Шинээр баригдсан 5 барилга дээр Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах Улсын комисс ажиллуулав.

“Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд Японы “ЖАЙКА” олон улсын байгууллагын шугамаар боловсруулсан Улаанбаатар хотын байр зүйн зургийн зохиогчийн болон ашиглах, эзэмших эрхийг шилжүүлэн авах санамж бичгийг байгуулав.

БНСУ-ын “Гоулд блок инвест” компанитай Баянголын аманд 2008-2018 онд нийт 12000 айлын орон сууц бүхий иж бүрэн хороолол барих санамж бичигт гарын үсэг зурав.

Канадын модон каркас бүхий байшингийн загвар төсөл хэрэгжүүлэх талаар канадын төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж байна.

Шинэ засгийн газар байгуулагдсаны 100 хоногийн арга хэмжээний үеэр барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, нийтийн аж ахуйн удирдах ажилтны зөвлөгөөнийг тус тус зохион байгуулав. Мөн “Барилга, орон сууц Экспо-2008” үзэсгэлэнг “Мишээл” экспо төвд зохион байгууллаа.

Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт:

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Тээврийн асуудлаарх ажлын хэсгийн 6 дугаар хуралдааныг 2008 оны 2 дугаар сарын 29-нөөс 3 дугаар сарын 2-ны өдрүүдэд Москва хотноо зохион байгуулав. Энэхүү хуралдаанаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын

Засгийн газар хоорондын “Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийг байгуулах тухай” 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх Монгол-Оросын ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулах, Монгол-Оросын хооронд агаарын шинэ зам, хаалга нээх, мөн хоёр улсын хооронд автотээврийн байнгын зорчигч тээврийн үйлчилгээний маршрут нээх, автотээврийн хэрэгслээр хил орчмын нутагт ачаа, зорчигч тээвэрлэх журам гаргах зэрэг асуудлуудаар тохиролцоонд хүрч протокол үйлдэв.

“Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын дамжин өнгөрөх тээврийн харилцаа” сэдэвт үндэсний семинарыг зохион байгуулж, уг асуудлаар Монголын талын баримтлах зөвлөмжийг гаргав.

“Транзит Монгол” хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулга, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд яамдын саналыг авч байна.

“Иргэний нисэхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газарт бүтцийн өөрчлөлт хийж, иргэний нисэхийн үйл ажиллагаанд тавих хяналтыг Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба бие даан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэв.

“МИАТ” ХК-ийн ажилчдын орон сууцыг хувьчлах асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэр гаргуулах хүсэлтийг Төрийн өмчийн хорооноос ирүүлсний дагуу холбогдох шийдвэрийн төсөлд санал авахаар яамдад хүргүүлээд байна.

Мөн “МИАТ” ХК-ийн хувьчлалын талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулга, холбогдох шийдвэрийн төслийг ЗГХЭГ-т хүргүүлэв.

Монгол Улсыг хөгжүүлэх сангаас “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн техник технологийг шинэчлэхэд зориулан түрээслүүлэхээр 3 илчит тэрэг, 150 төрөл бүрийн вагон худалдан авахад 15 тэрбум төгрөг хуваарилагдсантай холбогдуулан төсвийн хөрөнгөөр бий болох эдгээр хөрөнгийг 100 хувийн төрийн өмчит хуулийн этгээд /“Монголын төмөр зам” Хувьцаат компани/ байгуулж өмчлүүлэх асуудлыг боловсруулан Засгийн газраар шийдвэрлүүлэв.

“Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх Монголын талын ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай, мөн хэлэлцээрийн шинэчилсэн төслийн тухай танилцуулгыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулав.

“Ойрын болон дунд хугацаанд шинээр төмөр замын сүлжээ байгуулах хэтийн төлөвийн тухай” асуудлыг “Төмөр замын үндэсний сүлжээг өргөжүүлэх хэтийн төлөв, “УБТЗ” ХНН-ийн техникийн шинэчлэлийн хөтөлбөр” болгон өөрчилж Засгийн газарт болон ҮАБЗ-д танилцуулахаар хүргүүлэв.

Засгийн газрын хуралдаанаас “Монголшуудан” ХХК-ийг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны 67 хувийг төрийн эзэмшилд үлдээж 33 хувийг нь хөрөнгийн биржээр арилжих шийдвэр гаргав.

Засгийн газрын 2008 оны 12 дугаар тэмдэглэлийн дагуу хөдөө орон нутгийн шуудан хүргэлтийг сайжруулахад шаардагдах 220.0 сая төгрөгийг бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас санхүүжүүлэх талаар Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран санал боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэв.

Зам, тээвэр, аялал жуулчлалын болон Гадаад хэргийн сайд нарын хамтарсан тушаалаар “Хятадын жуулчдыг бүлгээр аялуулах тухай журам”-ыг батлуулав.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламж, “ЖАЙКА” олон улсын байгууллагын техникийн туслалцаагаар хэрэгжих “Иргэдийн оролцоотойгоор амьдрах орчинг нь сайжруулах технологи дамжуулах төсөл”-ийн санамж бичигт гарын үсэг зурав.

Улаанбаатар хотод гүүрэн гарц барих төлөвлөгөө, үндсэн зураг төслийн судалгааг Зам, тээвэр, аялал жуулчлалын яам, Япон Улсын “ЖАЙКА” олон улсын байгууллагатай хамтран 2008 оны 3 сараас эхлэн хэрэгжүүлэхээр болж, хэлэлцээрт гарын үсэг зурлаа.

Завхан, Говь-Алтай аймгуудын нисэх буудалд хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Заабар”, “Хурдны зам” компаниудтай гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлээ.

ОХУ-ын Москва хотноо 2008 оны 3 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохиогдсон “MITT-2008” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд ЗТАЖЯ-ны нэгдсэн зохион байгуулалт дор “Нью жуулчин” ХХК, “GBG” ХХК, МТЗ-ын Аялал жуулчлалын товчоо, “В мире фантазии” зэрэг 4 компанийн 7 төлөөлөгч оролцсон бөгөөд 15 кв.метр талбай авч тохижуулан Монгол Улсаа амжилттай сурталчлан оролцлоо.

ХБНГУ-ын Берлин хотноо зохиогдсон “ITB-2008” үзэсгэлэн яармагт ЗТАЖЯ-ны дэд сайдаар ахлуулсан 11 компанийн төлөөлөл оролцож, улс орноо сурталчиллаа.

Япон Улсын Осака хотын “Кансай” нисэх онгоцны буудалд зохиогдсон аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт дэлхийн 70 орны авиа компани, аялал жуулчлалын 150 байгууллагууд оролцлоо. Уг үзэсгэлэнд Монгол Улсыг төлөөлж “МИАТ” ХК болон Осака хотын Монгол-Японы төв хамтран оролцлоо.

2008 онд улсын төсөв, “Монгол Улсыг хөгжүүлэх сан”-гийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж эхлэх авто зам, гүүрүүдийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын ажлын явц 80 хувьтай байна.

Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр яам харьяа газрын ажилтнууд хариуцсан ажлын чиглэл болон салбарын бодлого, зохицуулалтын талаар авч явуулж буй үйл ажиллагааныхаа талаар танилцуулан, салбарын холбогдолтой хууль, дүрэм журмын эмхэтгэлийг тараав.

Түлш, эрчим хүчний салбарт:

Түлш, эрчим хүчний сайдын 2008 оны 40 дүгээр тушаалаар байгуулагдсан Улаанбаатар хотын эрчим хүчний тав дахь эх үүсвэрийн тендерийн баримт бичгийг боловсруулах ажлын хэсгээс баримт бичгийн I, III хэсэг буюу тендерт оролцогчдод өгөх заавар, үнэлгээний шалгуур, гэрээний ерөнхий нөхцөл, гэрээний тусгай нөхцөл, тендерийн урилга зэргийг боловсруулан зөвлөхтэй санал солилцож зөвлөгөө аван ажиллаж байна. Түүнчлэн цахилгаан станцын техник тоног төхөөрөмжид тавигдах техник, стандартчилал, байгаль орчны зэрэг шаардлагуудыг боловсруулж, цахилгаан, дулааны сүлжээний горим, ачааллын тооцоог хийж байгаа бөгөөд эдгээр арга хэмжээг дөрөвдүгээр сарын дундуур эхний төсөл байдлаар баталж дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Улаанбаатар хотын өмнөд 110/10/6 кВ-ын дэд станцад осол гарсантай холбогдуулан Түлш, эрчим хүчний сайдын тушаалаар ослын нөхцөл байдалд дүгнэлт хийх ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсгийн болон холбогдох мэргэжлийн хүмүүс цаг алдалгүй шуурхай ажиллаж, станцыг хэвийн байдалд нь оруулав. Ослын шалтгааныг цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний тоноглол нь хуучирсан, кабель шугамын хөндийрүүлэг муудсан, ашиглалтын хугацаа хэтэрсэн, эрчим хүчний үнэ, тариф нь зөвхөн зардлаа нөхөх хэмжээнд байгаа нь хөрөнгө оруулалт, техникийн шинэчлэл хийх нөхцөл бололцоог хязгаарлаж байна гэж дурджээ.

Эрчим хүчний салбарын аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор АНУ-ын Элчин сайдын яам, Ази Номхон далайн аюулгүй байдлын судалгааны төв, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран “Онцгой байдлын бэлэн байдал, эрсдэлийг бууруулах нь” сэдэвт сургалт семинарыг зохион байгуулсан бөгөөд “Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг сайжруулах”, “Эрсдэлийг бууруулах” зөвлөмжийг тус тус боловсруулан гаргаж Засгийн газарт өргөн барихаар тогтов.

АНУ-ын “Headwaters” компанитай хамтран “Нүүрс шингэрүүлэх технологи” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Үйлдвэр худалдааны яам, Байгаль орны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв, Шинжлэх ухааны академи, Хими технологийн хүрээлэн, Уул уурхайн хүрээлэн, Шинжлэх ухаан технологийн их сургууль, “Багануур” ХК, “Петровис” ХК, “Нүүрс” ассоциаци, Red hill, Camex болон бусад байгууллагуудаас нийт 80 орчим төлөөлөгч оролцож тавигдсан илтгэлийн хүрээнд байр суурь, санал бодлоо илэрхийлэв. Монгол Улс нүүрсний нөөцөөр дэлхийн эхний арван таван орны тоонд багтдаг, нүүрсний геологийн таамаг нөөц 152 тэрбум тонн бөгөөд цаашдаа өсөх хандлагатай, газрын тосны бүтээгдэхүүний хувьд 100 хувийн гадаад улсаас хамааралтай

нь нүүрсийг дотооддоо шингэрүүлэн түлш гарган авах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа юм. Энэ удаагийн хэлэлцүүлгээр нүүрсийг хийжүүлэн ашиглах талаар харилцан санал, мэдээллээ солилцлоо.

Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Түлш, эрчим хүчний сайдын “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай” 2008 оны 57 дугаар тушаалыг батлав.

Гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг 5.5 сая ам.доллар /“Эрчим хүчний хөтөлбөр-1” төсөл 863.0 мянган евро, “Дулааны 4 дүгээр цахилгаан станцын 2 дугаар шатны төсөл” 26.3 сая иен, “Эрчим хүчний төсөл” 1.05 сая ам.доллар, “Тайширын усан цахилгаан станц барих төсөл” 1.83 сая ам.доллар, “Богдын голын усан цахилгаан станцын шинэчлэлтийн төсөл” 182.0 мянган евро, “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах төсөл” 805.7 мянган ам.доллар/-аар хянан Сангийн яаманд уламжлан санхүүжүүлж, 40.0 мянган ам.долларын бараа материал, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэн, төслүүдийг хэрэгжүүлэгч нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг 16.0 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлж ажиллав.

Эгийн голын усан цахилгаан станцыг барих төслийг зогсоосонтой холбогдуулан тус станцын Түлш, эрчим хүчний сайдын багцад батлагдсан 1.229,5 сая төгрөгийн хөрөнгийг:

- “Хөдөөгийн эрчим хүчний хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах” төслийн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны зардалд /120.0 сая төгрөг/;
- Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Орон нутгийн дулаан хангамжийг сайжруулах төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зардалд /180.0 сая төгрөг/;
- Тайширын усан цахилгаан станцын зөвлөх үйлчилгээний зардалд /300.0 сая төгрөг/;
- Дөргөний усан цахилгаан станцын хамгаалалтын хашаа барих, машин техник худалдан авахад /72.4 сая төгрөг/, станцын зураг төслийг шинээр боловсруулсан зардалд /352.0 сая төгрөг/, мөн станцын төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зардалд /100.0 сая төгрөгийн/ тус тус зарцуулахаар шийдвэрлэв.

Говь-Алтай, Завхан аймгийн төвийн болон Тосонцэнгэлийн эрчим хүчний үйлдвэрт 2008 онд дизелийн түлш нийлүүлэхээр шалгарсан компаниудтай холбогдох гэрээг байгуулж хүргүүлэв.

2008 онд эрчим хүчний үйлдвэрүүдэд нийлүүлэгдэх дизелийн түлшний үнийн огцом өөрчлөлтийн үед нийлүүлэгчид төлөх үнийн тохируулга хийх аргачлалыг боловсруулан “НИК”, “Петровис” компаниудтай хамтарсан протокол гаргав.

Дэлхийн банкнаас 2008 оны 3 дугаар сарын 1-8-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулсан “Эрчим хүчний төсөл”-ийн ажлын уулзалтад яамны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцож төслийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв. Түүнчлэн Эрчим хүчний зохицуулах газрын үйл ажиллагаа, ойрын үед хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэж, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай хамтран ажиллах талаар санал солилцов.

АНУ-ын Төрийн департаментаас 2008 оны 3 дугаар сарын 3-7-ны өдрүүдэд Вашингтон хотноо зохион байгуулсан Сэргээгдэх эрчим хүчний олон улсын бага хуралд Түлш эрчим хүчний дэд сайд, яамны Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн дарга нар оролцож өөрийн улсад авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашдын хамтын ажиллагааны талаар байр сууриа илэрхийлэв.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт:

“Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”,

“Үрийн тариалангийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулиудын төсөл, үзэл баримтлалын төслийг танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэв.

“Үйлдвэрийн аргаар боловсруулж, дотооддоо борлуулах махыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар хүргүүлэв.

“Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

“Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 70 дугаар тогтоолоор батлуулав. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав. Уг хөтөлбөрийн талаар иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор “140 асуулт-хариулт бүхий гарын авлага” бэлтгэн хэвлүүлж, хүргүүлэхээр ажиллаж байна.

Шинээр эргэлтэд оруулах боломжтой атаршсан талбайн судалгааг орон нутгийн түвшинд нарийвчлан гаргах зорилгоор Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, холбогдох аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан ажлын хэсгийг томилон ажиллуулах тухай албан бичгийг аймгуудын Засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Засгийн газар байгуулагдсанаас хойших 100 хоногт хүнс, хөдөө аж ахуйн салбарт хийсэн ажлыг иргэдэд хүргэх, мэдээллийн хүртээмжийг өргөжүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулав.

Хаврын тариалалтад зориулан 6.0 мянган тонн буудайн үр импортоор авах ажлыг зохион байгуулж байна.

2008 оны хаврын хэрэгцээнд нийлүүлэх махны борлуулалтад хяналт тавьж, зохицуулалтын арга хэмжээ авч ажиллав.

“Цаа бугын удмын санг хамгаалах, цаачин иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах хөтөлбөр”, “Малын чанар сайжруулах хөтөлбөр”-ийн хүрээнд 2008 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

“Малын тэжээл” хөтөлбөрийн хүрээнд Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн санхүүжилтээр Хэнтий, Архангай, Булган, Хөвсгөл аймгийн 4 суманд тус бүр 25 га хадлангийн талбайг хашиж хамгаалах, ус хуримтлуулах хөвийг байгуулах ажлыг зохион байгуулав.

2008 онд мэрэгч амьтан, царцааны тархалт, хөнөөлийн тодотгох судалгаа хийх, дүгнэлт гаргах тухай гэрээг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй байгуулж, судалгааг Завхан, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Төв, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн оготно тархсан сумдад хийлгэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Дархан-Уул аймгийн Хонгор суманд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын шугамаар 4 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллуулан, дээж авч БНХАУ-д илгээн шинжлүүлж байна.

БНХАУ-ын Шинжан Уйгурт “Азиа-1” хэвшлээр малын шүлхий өвчин гарсантай холбогдуулан Баян-Өлгий, Ховд аймагт сэрэмжлүүлэг, албан захидал хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хооронд Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг холбогдох газруудад хүргүүлэв.

Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэн байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

Монгол Улсын ХХААЯ, ОХУ-ын ХААЯ хооронд Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн төслийг боловсруулж, ГХЯ-нд хүргүүлэв.

БНСУ-ын “КОЙКА” байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Мал эмнэлгийн лабораториудын хүнсний аюулгүй байдлын чадавхийг бэхжүүлэх” төслийн баримт бичгийг боловсруулав.

Гадаад бодлогын чиглэлээр:

НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээний /2007-2011/ эхний жилийн хэрэгжилтийн байдлыг авч хэлэлцэх уулзалтыг ГХЯ-нд зохион байгуулав.

Дамжин өнгөрөх тээврийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл, хавсралтуудын төслийг хэлэлцэх 8 дугаар уулзалтад бэлтгэх ажлын хэсгийн анхны уулзалтыг зохион байгуулав.

Саудын Арабын ханхүү Аль-Валид Бин Талал Аль-Сауд ажлын айлчлал хийв. Тэрбээр Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарт бараалхаж, хамтарч ажиллах, тухайлбал хөрөнгө оруулалт хийх боломжийн талаар санал солилцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд БНСУ-д айлчилж, БНСУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Ли Мен Багийн Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд оролцов.

Гадаад хэргийн сайд С.Оюуны 3 дугаар сарын 3-7-нд Япон Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улсад шинэ нисэх онгоцны буудал барих 28.8 тэрбум иений хөнгөлөлттэй зээлийн ноот бичигт гарын үсэг зурав.

ОХУ-ын ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга В.А.Соболев Монгол Улсад айлчлав. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар түүнийг хүлээн авч уулзав.

Европын Комиссын Гадаад харилцааны Ерөнхий Газрын Монголтой харилцах хэлтсийн дарга Ф.Жессэн тэргүүтэй төлөөлөгчид ажлын айлчлал хийв. Төлөөлөгчид Гадаад хэргийн сайдтай уулзаж, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Монгол-Британийн 9 дүгээр уулзалт болов. Уулзалтаар хоёр орны гадаад бодлого, бүс нутгийн болон олон улсын байгууллагын хүрээнд хамтран ажиллах асуудлууд, хоёр талын улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа, Британийн талаас хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт, боловсрол, соёл, шинжлэх ухаан, жуулчлал, банк, санхүүгийн хамтын ажиллагаа, орон нутгийн шууд харилцаа зэрэг өргөн хүрээтэй олон асуудлаар нийтдээ 30-аад илтгэл, мэдээллийг хэлэлцэж, санал солилцов.

Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын тухай асуудлыг Гадаад хэргийн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, цөмийн зэвсэгтэй холбоотой олон талт гэрээ хэлэлцээрт Монгол, Орос, Хятад нэгдэн орсон байдлын харьцуулсан судалгаа хийв.

Хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1988 оны гэрээний шинэчилсэн төслийн эхний үе шатны хэлэлцээг Бээжин хотноо 2 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд хийв.

Засгийн газрын хуралдаанаар Хилийн чанадад байгаа иргэдэд туслах сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай хэлэлцэж тогтоол гаргав. Ингэснээр олон жил яригдсан Хилийн чанадад байгаа иргэдэд туслах сан байгуулагдаж байгаа бөгөөд сангийн дансыг удахгүй нээхээр ажиллаж байна.

Монгол Улс, Монако Улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай асуудлыг Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлэв.

Кувейт Улсад Элчин сайдын яам нээх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулав.

Барилга, зам гүүрийн ажлын улирал эхэлж байгаатай холбогдуулан Хятадын иргэд хууль бусаар хөдөлмөр эрхлэх асуудалд анхаарлаа хандуулан хэд хэдэн арга хэмжээг авав. Үүнд: Хятадын ЭСЯ-ны зөвлөх Цай Ванруй яамны газрын дэд захиралтай уулзаж хятад иргэдийг хөдөлмөр эрхлүүлэхийг журамлах, Гадаад хэргийн сайдын айлчлалын үеэр энэ асуудалд анхаарал хандуулахыг санал болгов. Хятадын жуулчдыг бүлгээр авах тухай хоёр талын санамж бичгийг хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй, хяналттай, шуурхай болгох асуудлаар Гадаад хэргийн яам, Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн харъяатын асуудал эрхэлсэн алба болон аялал жуулчлалын компаниуд хамтарсан зөвлөлгөөн хийв. Хятадын жуулчдыг бүлгээр хүлээн авах журмыг Гадаад хэргийн яам, Зам тээвэр, аялал жуулчлалын яам хамтран шинэчлэн батлав.

Чех Улсад хөдөлмөр эрхлэх виз мэдүүлэхээр 6 сар дугаарлан эрх ашиг нь хохирч байгаа иргэдийн асуудлыг Чех Улсын ЭСЯ-нд ноотоор тавив. Хятадтай хөдөлмөрлөх

хүчнийг зохицуулах хэлэлцээр байгуулах, Чех Улсад хөдөлмөрлөх иргэдийн асуудлыг зохицуулах саналыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдад уламжлав.

“Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулав.

Монгол Улсын Засгийн газар 2008 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын “Хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийг баталсан тухай ноотыг Кувейтийн талд хүргүүлэв.

БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн даргын 3 дугаар сарын 26-30-нд Монгол Улсад хийх айлчлалын бэлтгэл ажлыг хангаж ажиллав. Бэлтгэлийн дүнг Засгийн газар, ҮАБЗ-д оруулж холбогдох шийдвэрийг гаргуулав.

“Гадаадын албан ёсны бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенц”-ийг соёрхон батлах тухайн хуулийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-аар батлуулав.

Монгол Улсын Засгийн газар Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийн оролцогч улсуудын дунд хэрэгжүүлэх туршилтын хяналтын хөтөлбөр (pilot review program)-т хамрагдах сонирхолтой байгааг Конвенцийн Оролцогч улсуудын Бага хурлын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэв.

Батлан хамгаалах салбарт:

“Дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулах төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдын тоо, цэрэг халалт, таталтын хугацаа тогтоох тухай”, “2008 онд цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай” асуудлуудыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэлээ.

Мөн “2009 онд Зэвсэгт хүчний 256 дугаар ангитай дайчилгаатай хээрийн сургууль явуулах тухай”, “Бангладеш Улсад зохион байгуулагдах олон үндэстний салаадын хээрийн сургуульд Зэвсэгт хүчнээс цэргийн баг оролцуулах тухай”, “Хааны эрэлд-2008” олон улсын хамтарсан энхийг сахиулах ажиллагааны хээрийн сургалт, дадлагыг зохион байгуулж явуулах тухай” асуудлуудыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэлээ.

2005-2006 онд батлагдсан хуулиудад дайны байдлын үед мөрдөхөөр үйлчлэлийг нь зогсоох, хязгаарлах, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиудын нэр, заалтын жагсаалт гаргаж, тайлбар, үндэслэлийг боловсруулж байна.

Батлан хамгаалах салбарын бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлыг Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгийн газар, Цэргийн штабтай хамтран Сэлэнгэ аймагт зохион байгууллаа.

Шинэ Засгийн газар байгуулагдснаас хойшхи 100 хоногт хийсэн ажлыг сурталчилж, Батлан хамгаалах яамны нээлттэй мэдээллийн өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр 800 гаруй цэргийн албан хаагч, ард иргэдэд хуулийн зөвлөгөө, архивын лавлагаа зэрэг үйлчилгээг хүргэлээ.

“Монгол Улсын зарим нутаг дэвсгэрт тэсэрч, дэлбэрэх зүйлийг хайн илрүүлж, аюулгүй болгох тухай” асуудлаар Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Батлан хамгаалах салбарын 2008 оны хэрэгцээнд урсгал төсвийн зардлаар худалдан авах бараа, ажил үйлчилгээний бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулахаар зарласан тендерийг үнэлж, бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулах эрхийг захиалагч байгууллагад олгохоор бэлтгэж байна.

Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд татан буугдсан зарим цэргийн анги, байгууллагын эзэмшил газрыг зарим офицер, ахлагч нарт эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр Баянзүрх дүүргийн газрын албанд санал хүргүүлээд байна.

Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 72 дугаар дэлгүүрийн зүүн талд цэргийн албан хаагчдад хөнгөлттэй үнээр хувьчлах зориулалтаар баригдаж байгаа 48 айлын орон сууцны барилгыг орон сууцанд орох хүмүүсээс хөрөнгө төвлөрүүлэх,

Засгийн газрын бондны урт хугацаатай зээлд хамруулахаар холбогдох байгууллагад санал хүргүүлээд байна.

Зэвсэгт хүчний 2007-2008 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нартай албан тушаалтны бэлтгэл сургалт, гэрээт цэргийн I, II жилийн цэргийн албан хаагчидтай мэргэжлийн болон мэргэжлийн гүнзгийрүүлсэн сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, салбарын жигдрэлтийг хангах сургалтыг тус тус зохион байгууллаа.

ЗХЖШ-аас 2008 онд зохион байгуулах хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 032, 065, 124, 189 дүгээр ангиудын цэргийн сургалт бэлтгэлийн явц байдлыг шалгаж, илэрсэн дутагдлыг засах талаар хугацаатай үүрэг өгч хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллав.

Мөн мэргэн буудагчийн томилгоот бүлэг бүхий Зэвсэгт хүчний ангиудын мэргэн буудагчдын бүлгийн бэлтгэл, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор албан даалгавар боловсруулан хүргүүлэв.

“Цэргийн албаа үлгэр жишээчээр хааж, цэргийн зохих мэргэжил эзэмшсэн байлдагч, түрүүчийг хугацаа дуусахаас 3 хүртэлх сарын өмнө бэлтгэлээр халах журам”-ын дагуу цэргийн албаа үлгэр жишээ хаасан 208 хугацаат цэргийн албан хаагчийг хугацаанаас нь өмнө бэлтгэлээр халж, орон нутагт нь хүргэх ажлыг зохион байгуулж байна.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн IX ээлжийн бүрэлдэхүүн Ад Дивинях хот дахь “Эко” баазын аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын үүргээ амжилттай биелүүлж байна.

Сиерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй Y ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн болон Баруун Сахар, Конго, Судан, Этиоп, Эритри, Гүржид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний 9 офицер цэргийн ажиглагчийн үүргээ хэвийн гүйцэтгэж байна. Этиоп, Эритрид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд өөрчлөлт орсны улмаас Монгол Улсын Зэвсэгт хүчнээс цэргийн ажиглагчийн үүрэг гүйцэтгэж байсан 3 офицер хугацаанаасаа өмнө эх орондоо ирлээ.

“Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-т оролцож байгаа сургалтын хөдөлгөөнт багийн VIII ээлжийн бүрэлдэхүүн эвслийн хүчний сургалтын нэгдсэн төв “Феникс” баазад үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

АНУ-ын “Даян дэлхийн энхийг дэмжих санаачилга сан”-тай хамтран НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны штабын ажилтны дамжааг БХИС-ийн сургалтын материаллаг баазыг түшиглэн Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Зэвсэгт хүчний анги, байгууллагын 33 офицерыг хамруулан зохион байгуулж явууллаа.

Зэвсэгт хүчний “Сахилгын зөвлөлгөөн”-ийг бүсчлэн зохион байгуулж, цэргийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх арга замын талаар хэлэлцэж, уриалга гаргалаа.

Хууль зүйн чиглэлээр:

Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Орон гэргүй иргэдийг дэмжих тухай”, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч ажиллуулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүллээ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Сургуулийн өмнөх боловсролын тухай зэрэг 7 хуулийн төсөл болон “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Тогтоолын

хавсралтад нэмэлт оруулах тухай”, “Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, “Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газруудыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай”, “Стратегийн нөөцийн бараа материалын нэр төрөл тогтоох тухай” зэрэг УИХ-ын 4 тогтоолын төсөл, Монгол Улсын Засгийн газар, Итали улсын Засгийн газар хоорондын “Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

УИХ-ын гишүүн Г.Батхүүгийн санаачилсан Автотээврийн тухай, Замын хөдөлгөөний тухай, Ахмад настны нийгмийн хамгаалал, Боловсролын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалал, Цагдаагийн байгууллагын тухай хуулиудад болон УИХ-ын гишүүн Д.Ганхуяг, С.Ламбаа нарын санаачилсан Орон гэргүй иргэдийг дэмжих тухай зэрэг нийт 7 хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлээ.

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гадаадын албан ёсны бичиг баримтыг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенцийг соёрхон батлах тухай, Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эх орны хишиг сангийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг нийт 9 хуулийн төслийн үзэл баримтлал, Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай, 2008 онд Монгол Улсын иргэдэд хишиг хүртээх мөнгөний хэмжээг тогтоох тухай зэрэг УИХ-ын 2 тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд заасан журмын дагуу тус тус хянаж шийдвэрлэв.

Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг сайжруулах зарим арга хэмжээний тухай, Дархан-Сэлэнгийн бүсийн Төмөртэй, Хуст-Уул, Төмөртолгойн төмрийн хүдрийн ордыг ашиглах үйлдвэрийн цогцолбор байгуулах зорилгоор хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалтын журмын төсөл, Хилийн мэргэжлийн хяналтыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай зэрэг Засгийн газрын 21 шийдвэрийн төсөлд санал өгөв.

Баг, хороо, сум, дүүргийн Засаг дарга нарт зориулсан хуулийн эмхэтгэлийг хэвлүүлж, түгээх ажлыг зохион байгуулав.

Шинэ Засгийн газар байгуулагдсаны 100 хоногийн ажлын хүрээнд тус яам болоод харъяа агентлагийн төлөөлөл оролцсон нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулав.

Энэ өдөр яамны газар, хэлтэс, харъяа агентлаг, байгууллагууд иргэдэд зориулсан үйлчилгээг нэг цэгээс үзүүлэн ажиллав. Үүнд: Иргэний бүртгэл, мэдээллийн ажилтнууд иргэний үнэмлэх болон гадаад паспортын үйлчилгээ, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албанаас зөвшөөрөл, визийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд өмгөөлөгчид хууль зүйн зөвлөгөө өгч, хилийн цэрэгт алба хааж буй албан хаагчид болон хорих ангид ял эдэлж буй хүмүүстэй ар гэрийнхнийг нь утсаар яриулж, тус арга хэмжээний үеэр давхардсан тоогоор нийт 205 иргэнд үйлчиллээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар болон хамтран баталсан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй хүчин төгөлдөр эрх зүйн 32 актыг “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ”-нд байршуулав.

Хууль тогтоомжийн бүртгэл, лавламжийн нэгдсэн санд нийт 45 эрх зүйн акт бүртгэсэн. Үүнд: Хууль 9, УИХ-ын тогтоол 6, Засгийн газрын тогтоол 20, Ерөнхий сайдын захирамж 2, Ерөнхийлөгчийн зарлиг 6, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 2-ыг бүртгэлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

